



**НИЙСЛЭЛИЙН
НИЙТИЙН ТЭЭВРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 02 өдөр

Дугаар Б/08

Улаанбаатар хот

┌ Х.Нинад цалинтай чөлөө, буцалтгүй
тусламж олгох тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/817 дугаар захирамжаар батлагдсан “Нийтийн тээврийн үйлчилгээний газрын дүрэм”-ийн 2.5.3, Хөдөлмөрийн дотоод журмын 6.19.1, 7.3.10-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Тус газрын Техникийн хяналтын үзлэгийн төвийн Техникч Хадаагийн Нинагийн төрсөн эцэг таалал төгссөн тул 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс ажлын 10 хоногийн цалинтай чөлөө олгож, нэг удаагийн буцалтгүй тусламж 200.000 төгрөг / хоёр зуун мянга /-ийг олгосугай.

2. Буцалтгүй тусламжийн зардлыг нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшууллын зардлаас тооцож олгохыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн Ахлах нягтлан бодогч /Э.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Х.Нинагийн чөлөөтэй байх хугацаанд албан тушаалын чиг үүргийг хэвийн явуулахад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Техникийн хяналтын үзлэгийн төвийн дарга /Д.Галбадрах/-д үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга /М.Мөнхбаяр/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Ч. САЙХАНБАЯР